

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Африкийн ямар улсаас Газар Дундын тэнгис рүү шууд гарч болох вэ? (1 оноо)
A. Конго B. Танзани C. Судан D. Ливи E. Сенегал
2. Аль нь Энэтхэгийн далайн хүйтэн урсгал вэ? (1 оноо)
A. Гольфстрим B. Мозамбик C. Бенгель D. Перу E. Сомали
3. Хойд тропикийн шугам ямар эх газруудыг дайран өнгөрдөг вэ? (1 оноо)
A. Еврази, Хойд Америк, Австрали B. Еврази, Өмнөд Америк, Хойд Америк
C. Хойд Америк, Африк, Австрали D. Хойд Америк, Еврази, Африк
E. Африк, Өмнөд Америк, Австрали
4. Туул гол Хэрлэн мөрний хэд дэх эрэмбийн цутгал вэ? (1 оноо)
A. 1 B. 2 C. 3 D. 4 E. Цутгал биш
5. Аль нь Пермийн галавт үүссэн нүүрсний орд газар вэ? (1 оноо)
A. Могойн гол B. Налайх C. Багануур
D. Тавантолгой E. Хар Тарвагатай
6. Цэгийн оронд тохирох үгийг зөв дарааллаар нь сонгоно уу. Монгол орон нь ийн их цөл,ийн өргөн уудам хөвч тайга хоёрын заагт оршдог, үзэсгэлэнт газар нутаг ихтэй, байгалийн онгон төрх нь хэвээр хадгалагдан үлдсэн цөөхөн орны нэг юм. (1 оноо)
A. Сибир, Төв Ази B. Дундад Ази, Сибир C. Төв Ази, Сибир
D. Дундад Ази, Атакам E. Зүүн Ази, Такал-Макан
7. Иргэн А сувилалд эмчлүүлэхээр Жанчивлангийн рашаан сувиллын газар руу явжээ. Тус рашаан аль аймагт орших вэ? (1 оноо)
A. Сэлэнгэ B. Дорноговь C. Говьсүмбэр D. Төв E. Хэнтий
8. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Нэг дор орших олон үйлдвэрийн газрууд нэгэн төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг гэж нэрлэнэ. (1 оноо)
A. Үйлдвэрийн бөөгнөрөл B. Үйлдвэрийн хоршилт
C. Үйлдвэрийн төрөлжилт D. Комбинат E. Үйлдвэрийн цэг
9. Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд Монгол улсын Д.Н.Б-ий 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
A. Стратегийн B. Ердийн C. Түгээмэл D. Орон нутгийн E. Холимог
10. Нутгийн шилмэл омгийн тэмээ аль нь вэ? (1 оноо)
A. Говь-Алтайн тулман хөхт B. Баяндэлгэрийн улаан
C. Талын улаан D. Үзэмчин E. Хэцийн хүрэн
11. Манай орны тээврийн салбарт ачаа тээврээр тэргүүлэх салбар аль нь вэ? (1 оноо)
A. Авто тээвэр B. Агаарын тээвэр C. Ердийн хөсөг
D. Төмөр замын тээвэр E. Усан тээвэр
12. ДЦС өдөрт 5 тн нүүрс шатаадаг бол нэг өдөрт шатаах нүүрс нь ямар хэмжээний дулаан ялгаруулах вэ? (1кг нүүрс шатахад 7.0 ккал дулаан ялгарна). (1 оноо)
A. 35000 ккал B. 3500 ккал C. 35000 ккал D. 350000 ккал E. 350 ккал
13. Берлин (Х.Ө 52°20', ЗУ 13°) хотоос Рим (Х.Ө 42°, ЗУ 13°) хот руу зорчигч тээврийн автобус хөдөлжээ. Рим хот Берлинээс аль зүгт орших вэ? (1 оноо)
A. Баруун B. Өмнө C. Зүүн D. Зүүн хойд E. Хойд

14. Хөгжиж буй орнууд дотор “Шинээр Аж Үйлдвэржиж буй орнууд” гэх бүлэгт багтах улсыг сонгоно уу. (1 оноо)
A. Бразил B. Судан C. Мали D. Швед E. Намиб
15. Аль нь НҮБ-ын албан ёсны хэлэнд багтдаг хэл вэ? (1 оноо)
A. Швед B. Испани C. Итали D. Португали E. Ирланд
16. Тодорхой нэг бүс нутагт байх улсууд үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, санхүүгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аж ахуйгаа нэгтгэх үйл явцыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
A. Эдийн засгийн интеграци B. Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарь
C. Эдийн засгийн чөлөөт бүс D. Олон улсын тээвэр зуучлал
E. Үндэстэн дамнасан корпорац
17. Дэлхийн хэмжээний шашин биш боловч 800 сая гаруй хүн шүтдэг, Энэтхэгийн үндэсний хэмжээний том шашинг юу гэж нэрлэдэг вэ? (1 оноо)
A. Хиндүизм B. Шинто C. Күнз D. Даосизм E. Мормон
18. Өгөгдсөн улсуудаас хүн амын нягтшилаар хамгийн өндөр орон аль нь вэ? (1 оноо)
A. Герман B. Монгол C. Казакстан D. Саудын араб E. Гренланд
19. Газрын тос олборлолтоор тэргүүлэгч орнуудыг сонгоно уу. (1 оноо)
A. Хятад, Австрали B. Япон, Иран C. Индонез, Шинэ Зеланд
D. Герман, Түрк, Күвейт E. Саудын Араб, ОХУ, АНУ
20. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. XX зууны 40-өөд оноос эхлэн мэдээллийн технологи болон цөмийн эрчим хүч, сансрын техникийн хөгжил шинэ шатанд гарч нийгмийн харилцаа, үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд чанарын хувьсгал хийсэн. Энэ үйл явцыггэнэ. (1 оноо)
A. Аж үйлдвэрийн хувьсгал B. Нийгмийн хувьсгал
C. Шинжлэх Ухаан Техникийн Хувьсгал D. Нанотехнологийн хувьсгал
E. Соёл иргэншлийн хувьсгал
21. Дэлхийн далайн тээвэрт чухал ач холбогдол бүхий Атлантын далайн боомт хотыг нэрлэнэ үү. (1 оноо)
A. Владивосток B. Шанхай C. Лондон D. Сантьяго E. Осака
22. Ундны усны хүрэлцээ бага, байнга усны дутагдалтай байдаг бүс нутаг аль нь вэ? (1 оноо)
A. Зүүн Европ, Өмнөд Африк B. Төв Америк, Карибын орнууд
C. Төв Ази, Скандинавын орнууд D. Сахар, Сахелын орнууд
E. Хойд Америк, Зүүн Ази
23. Гайтид 2010 оны 1 сард байгалийн ямар гамшигт үзэгдэл болсон бэ? (1 оноо)
A. Ойн түймэр B. Газар хөдлөлт C. Галт уулын дэлбэрэлт
D. Үер E. Хар салхи
24. Амьтны гаралтай рельеф (хотгор гүдгэр)-ийн төрөл юу вэ? (1 оноо)
A. Хөөө, шүрэн арал B. Уурхай карьер, ухсан нүх
C. Довцог, элсэн манхан D. Өрх тогоо E. Мөсөн гол, намаг
25. Илүү сартай жилд тэргэл сар хэдэн удаа гарах вэ? (1 оноо)
A. 11 B. 10 C. 13 D. 14 E. 15
26. Өгөгдсөн үндэстнээс 100 саяас дээш хүн амтай үндэстнийг нэрлэнэ үү. (1 оноо)
A. Чех B. Хинди C. Армян D. Франц E. Польш


27. Температур нь маш огцом нэмэгддэг, нарны цацрагийн нөлөөгөөр молекул нь иончлогддог агаар мандлын үе давхаргыг нэрлэнэ үү. (1 оноо)
 А. Тропосфер В. Стратосфер С. Мезосфер Д. Термосфер Е. Экзосфер

28. Цэгийн оронд тохирох үгийг сонгоорой. Дэлхийн гадаргын тухайн нэгж талбай дээр дарж байгаа агаарын баганын жинг..... гэнэ. (1 оноо)
 А. Агаарын масс В. Агаарын төлөв С. Агаарын даралт
 Д. Агаарын хөдөлгөөн Е. Агаарын температур

29. Газрын зураг дээр ижил өндөртэй гадаргыг холбосон шугамыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
 А. Изотерм В. Изогон С. Изогипс Д. Изобат Е. Изобар

30. Эдийн засгийн Төвийн бүсийн тулгуур хотууд аль нь вэ? (1 оноо)
 А. Сүхбаатар, Сайншанд В. Сүхбаатар, Зуунмод С. Сайншанд, Дархан
 Д. Сайншанд, Зуунмод Е. Дархан, Зуунмод

31. Дараах цэгийн солбицлыг тодорхойлно уу. (1 оноо)




- А. $\Theta\Theta 54^{\circ}30'$, $\text{ЗУ } 93^{\circ}30'$
- В. $\text{Х}\Theta 54^{\circ}30'$, $\text{ЗУ } 93^{\circ}30'$
- С. $\Theta\Theta 55^{\circ}30'$, $\text{БУ } 94^{\circ}30'$
- Д. $\text{Х}\Theta 55^{\circ}30'$, $\text{ЗУ } 94^{\circ}30'$
- Е. $\Theta\Theta 54^{\circ}30'$, $\text{БУ } 95^{\circ}30'$

32. Уулсын тогтолцоог салбар уулстай нь харгалзуулсан хувилбарыг сонгоно уу. (1 оноо)

- | | | |
|--------------------|---|-------------------|
| 1. Алтайн нуруу | А. Соёны нуруу, Баяны нуруу, Хорьдил Сарьдаг | |
| 2. Хангайн нуруу | В. Их Хэнтий, Бага Хэнтий, Асралтхайрхан | |
| 3. Хэнтийн нуруу | С. Ханхөхий, Булнай, Тарвагатай | |
| 4. Хөвсгөлийн уулс | Д. Таванбогд, Цамбагарав, Баянцагаан, Их Богд | |
| А. 1D, 2C, 3A, 4B | В. 1C, 2D, 3B, 4A | С. 1A, 2C, 3B, 4D |
| Д. 1D, 2C, 3B, 4A | Е. 1D, 2B, 3C, 4A | |

33. Зурагт 1-ийн тоогоор тодруулсан Тусгай Хамгаалалттай газар нутгийн нэрийг зөв сонгоно уу? (2 оноо)




- А. Горхи Тэрэлжийн Байгалийн Цогцолборт газар
- В. Увс нуурын Дархан Цаазат газар
- С. Тарвагатайн нурууны Байгалийн Цогцолборт газар
- Д. Сийлхэмийн нурууны Байгалийн Цогцолборт газар
- Е. Хөвсгөл орчмын Байгалийн Цогцолборт газар

34. Дараах өгөгдлийг уншаад зөв 2 өгүүлбэрийг сонгоно уу. (2 оноо)

- 1) Хөвөнг зөвхөн экваторын чийглэг бүсэд тариалдаг.
- 2) Баруун Европ дэлхийн хөвөн импортлогч гол бүс нутаг юм.
- 3) Хятад хөвөнгийн үйлдвэрлэл болон экспортоор тэргүүлдэг.
- 4) Узбекистанд хөвөн тариалахад тохиромжгүй.

A. 1 ба 2 B. 2 ба 3 C. 3 ба 4 D. 1 ба 4 E. 2 ба 4

35. Зураг дээр 1-ийн тоогоор тэмдэглэсэн хилийн боомтыг нэрлэнэ үү. (2 оноо)




- A. Хавирга
- B. Бичигт
- C. Эрээнцав
- D. Ульхан
- E. Арц суурь

36. Туйл талаасаа хамгийн дулаан сарын 0°C-ийн изотермээр хүрээлэгдэх бөгөөд үндсэндээ тундрын хил болдог дэлхийн дулааны бүслүүр аль нь вэ? (2 оноо)

- A. Халуун бүслүүр
- B. Сэрүүн бүслүүр
- C. Хүйтэн бүслүүр
- D. Мөнх хүйтэн бүслүүр
- E. Бүгд

37. Зурагт А үсгээр тэмдэглэсэн уулсын тогтолцоог нэрлэнэ үү? (2 оноо)




- A. Хянганы уулс
- B. Бүтээлийн нуруу
- C. Хэнтийн нуруу
- D. Булнайн нуруу
- E. Хорьдил Сарьдагийн нуруу

38. Асуултын тэмдгийн оронд байх газарзүйн объектийн нэрийг сонгоно уу. (2 оноо)




- A. Эх газар
- B. Далай
- C. Булан
- D. Хоолой
- E. Хойг

39. Монгол орны угсаатан ястнуудын голлон амьдрах нутгийг өнгөт дэвсгэрийн аргаар дүрсэлсэн зурагт 1 ба 2-ын тоогоор ямар ястныг тэмдэглэсэн бэ? (2 оноо)



- A. 1- Дархад, 2- Захчин В. 1- Урианхай, 2- Дөрвөд
 C. 1- Баяд, 2- Торгууд D. 1- Дөрвөд, 2- Барга E. 1-Цаатан, 2-Хотгойд

40. Зургийг ажиглаад 1-ийн тоогоор заасан хавтангуудын хилийг тодорхойлно уу. (2 оноо)



- A. Ойртон нийлж буй хавтангийн хил зааг
 B. Холдон салж буй хавтангийн хил зааг
 C. Шилжин зөрж буй хавтангийн хил зааг
 D. Хавтангийн хөдөлгөөнийг судлах боломжгүй
 E. Хавтангууд хөдөлдөггүй



41. Дараах фото зургуудыг эх газартай нь зөв тохируулсныг сонгоно уу. (2 оноо)



1. **A. Африк** 2. **B. Австрали** 3. **C. Өмнөд Америк** 4. **D. Хойд Америк**


- A. 1C, 2A, 3D, 4B B. 1B, 2C, 3A, 4D C. 1D, 2B, 3E, 4B
 D. 1A, 2B, 3C, 4D E. 1D, 2C, 3A, 4B

42. Байрзүйн зургийн таних тэмдгүүдийг зөв харгалзуулсан хувилбарыг нэрлэнэ үү. (2 оноо)




- A. 1A, 2B, 3C, 4D B. 1C, 2D, 3B, 4A C. 1C, 2A, 3B, 4D
 D. 1B, 2A, 3D, 4C E. 1C, 2D, 3A, 4B

43. Нарны эгц тусгалыг үзүүлсэн тахир шугам дээр А гэж тэмдэглэгдсэн газарт хэдэн сарын хэдний өдөр болж байх боломжтой вэ? (2 оноо)



- A. 9 сарын 23 B. 2 сарын 23 C. 6 сарын 22
 D. 12 сарын 22 E. 10 сарын 23

44. Австралиас Энэтхэг хүртэл өгөгдсөн сумны дагуу (А-аас В) ертөнцийн зүг чигийг тодорхойлно уу. (2 оноо)




А. Зүүн хойд В. Баруун өмнөд С. Баруун хойд D. Зүүн өмнөд E. Зүүн

45. Завхан голын эх нь д.т.дээш 3000 м, урт нь 808 км, адаг нь д.т.дээш 1030 м бол голын унал хэд вэ? ($U=N_1-N_2$) (2 оноо)


А. 1930 м В. 1970 м С. 2970 м D. 3000 м E. 1070 м

46. Зураг дээр 1-ийн тоогоор тэмдэглэсэн улсад эрчимтэй хөгжсөн аж ахуй, үйлдвэрлэл аль нь вэ? (2 оноо)




А. Төмөрлөг, нүүрс, хонины аж ахуй
 В. Цаас целлюлоз, кофе, цагаан будаа, гар урлал
 С. Дарс, хөлөг онгоц, банк санхүү, цай
 D. Какао, үслэг эдлэл, мод, модон бүтээгдэхүүн
 E. Хүнсний ногоо, тэмээний аж ахуй, шашны аялал жуулчлал

47. Масштабыг томоос нь жижиг рүү дараалуулан бичсэн хариултыг сонгоно уу. (2 оноо)




- A. 1, 2, 3
- B. 2, 3, 1
- C. 2, 1, 3
- D. 3, 1, 2
- E. 1, 3, 2

48. Зургийг ажиглаад эдийн засгийн Төвийн бүсэд багтах аймгийг олно уу? (2 оноо)




- A. 3 ба 4
- B. 2 ба 6
- C. 1 ба 4
- D. 5
- E. 6

49. Манай орны уулсад 3300 м-ээс дээш өндөрт үүсэх өндрийн бүслүүр аль нь вэ? (2 оноо)




- A. Хээр
- B. Ойт хээр
- C. Тайга
- D. Таг
- E. Мөнх цас

50. Энэ нөхцөлд агаарын хамгийн их даралттай цэг аль нь байж болох вэ? (2 оноо)



- A. А цэг
- B. В цэг
- C. С цэг
- D. D цэг
- E. Далайн түвшинд

51. Цэгийн оронд тохирох нэрийг сонгоно уу. Хотгор гүдгэрийн зүсэлт нь эх газрыг баруунаас зүүн тийш огтлон гарсан байна. (2 оноо)



- A. Африк
- B. Австрали
- C. Антарктид
- D. Өмнөд Америк
- E. Европ

52. Сумаар ямар бүтээгдэхүүний экспортын чиглэлийг илэрхийлж байна вэ? (3 оноо)



- A. Оёдол нэхмэл, ой мод
 B. Газрын тос
 C. Буудай
 D. Цагаан будаа
 E. Хүнс

53. А улсын гадаад худалдааны эргэлт 2010 онд 650 сая америк доллар байсан бол 2011 онд 720 сая америк доллар болж өсчээ. Жилийн өсөлт хэдэн хувь болсон бэ? (3 оноо)
 A. 12.7% B. 20.1% C. 15.2% D. 9.6% E. 10.7%

54. Гол мөрдийг цутгах газар, тивтэй нь зөв тохируулна уу? (3 оноо)

- | | | |
|--------------|------------------------|----------------|
| 1. Миссисипи | A. Их Австралийн булан | a. Австрали |
| 2. Муррей | B. Арабын тэнгис | b. Ази |
| 3. Инд | C. Мексикийн булан | c. Африк |
| 4. Нил | D. Газар дундын тэнгис | d. Хойд Америк |


- A. 1-Cd, 2-Dc, 3-Ba, 4-Ab
 B. 1-Da, 2-Ac, 3-Bb, 4-Cd
 C. 1-Dd, 2-Cc, 3-Ab, 4-Ba
 D. 1-Cd, 2-Aa, 3-Bb, 4-Dc
 E. 1-Cd, 2-Aa, 3-Bc, 4-Db

55. Манай орны зарим хотуудын жилд унах хур тунадас, агаарын температур болон гадарга, газарзүйн байрлалыг тодорхойлсон хүснэгтийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хотыг сонгоно уу? (3 оноо)

Хотууд	Өргөрөг	Өндөр (м) д.т.д	Дундаж температур (t °C)			Жилд унах тунадас (мм)
			жилийн	I сар	YII сар	
Улаангом	XӨ 49°58'	939	-3.7°	-32°	+16°	138
?	XӨ 46°41'	981	+0.6°	-21°	+20°	203.7
Алтай	XӨ 46°22'	2181	-1.5°	-19°	+14°	171.2
Даланзадгад	XӨ 43°34'	1465	+4°	-16°	+21°	129.5

- A. Улаанбаатар B. Баруун-Урт C. Мөрөн D. Замын үүд E. Сүхбаатар

56. Монгол улсын хүн амын тооллоготой холбоотой тоон мэдээллүүдийг өгөв. Графикт дүрсэлсэн өгөгдлүүдийг ажиглаад өгөгдсөн хариултуудаас үнэн нэг өгүүлбэрийг сонгоно уу? \1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, ердийн өсөлт\ (3 оноо)



- A. Ердийн өсөлт 1963 оноос хойш өнөөг хүртэл тогтмол буурч ирсэн.
 B. Ердийн өсөлт ба төрөлтийн хэмжээ хоёул хамгийн өндөр байсан нь 1963 оны тооллогоор байсан.
 C. 1935 онтой харьцуулахад 2010 онд нас баралтын хэмжээ 8 дахин буурчээ.
 D. Төрөлтийн тоо 2010 оны тооллогоор сүүлийн 30 жилд хамгийн өндөр байв.
 E. Нас баралтын тоо хэмжээ 1935 оноос 1979 оны хооронд тогтмол буурч ирсэн.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл, эцсийн хариу 5650 гэж гарсан бол a-5, b-6, c-5, d-0 гэж бөглөнө.

- 2.1. Мурманск хот болон АНУ-ын ижил өргөрөгт орших Номе хотын цаг уурын станцын мэдээгээр 2 хотын агаарын температур ижил байжээ. Мурманскт 5°C байсан бол Номе хотын агаарын температур франгейтээр хэд байсан бэ? / $t^{\circ}\text{F}=9/5t^{\circ}\text{C}+32$ / (3 оноо)
- 2.2. А ба В хотын хооронд 10 тн-ын даацтай машинаар цемент ачиж 15 удаа тээвэрлэхдээ 52.500 тн*км ачаа эргэлт хийсэн бол хоёр хотын хооронд хэдэн км зайтай вэ? ($S = E/A$) (4 оноо)
- 2.3. Тухайн үеийн агаарын температур -10°C , чийгийн багтаамж 2.5 г/м^3 , харьцангуй чийг 60% байсан бол дутмаг чийгийг тооцно уу. (4 оноо)
- 2.4. Бээжин (8-р цагийн бүс) хотоос Москва (2-р цагийн бүс) хот руу 15 цагт хөөрсөн онгоц Москвад тухайн бүсийн цагаар 15 цагт буужээ. Онгоц хэдэн цаг ниссэн бэ? (4 оноо)